



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 1428

Мандалговь

"Хөгжилд- залуучуудын оролцоо" уриан
дор аймгийн залуучуудын чуулганыг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын а, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.3 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Залуучуудын нийгмийн хөгжилд оролцох эрх, үүргийг чиглүүлэх, оролцоог нэмэгдүүлж, хөгжүүлэх зорилгоор "Хөгжилд- залуучуудын оролцоо" уриан дор аймгийн залуучуудын чуулганыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ахлагч: Ж.Мөнхчулуун (Аймгийн Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга: Ц.Ганзориг (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)
Гишүүд: А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Ц.Бумангэрэл (Боловсрол, соёл урлагийн газрын дарга)
Г.Бат-Орших (Эрүүл мэндийн газрын дарга)
Ж.Өлзийжаргал (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
Г.Хишигдаваа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
Д.Доржсүрэн (Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга)
Б.Оюунчимэг (Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга)
Б.Пүрэвжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Х.Төмөрбат (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвийн нарийн бичиг)

Хоёр. Аймгийн залуучуудын чуулганыг чанартай зохион байгуулж, танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч (Ж.Мөнхчулуун), гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191215